



11.

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 03

Аргатай

Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл сонгон  
шалгаруулах тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Тэргүүлэх чиглэлийн дагуу төсөл хүлээн авах хугацааг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 15 -ны хооронд зохион байгуулсугай.

2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

3. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулахдаа журмын 5, 6 дугаар зүйлүүдийг мөрдлөг болгон ажиллахыг Төсөл сонгон шалгаруулах хорооны дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Баярхүү)-д үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* Д.ЭРДЭНЭБАТ